



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/279

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14.1, 20.4, Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 246 дугаар тогтоолын 4.3.1, 4.3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг нэгдүгээр, Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/390 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal

141200963

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 04 -ны өдрийн А/279 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Албаны нууцад хамаарах мэдээлэл
1.	Салбарын сайдын эрхлэх ажлын хүрээнд батлан гаргасан албаны нууцад хамаарах тушаал, шийдвэр, бусад холбогдох баримт бичиг
2.	Эрүүл мэндийн салбарт захиалгаар үндэсний хэмжээнд хийгдэх тэргүүлэх чиглэлийн судалгаа, шинжилгээ, төсөлт ажлын нууцалбал зохих хэсэг
3.	ХДХВ болон бусад халдварт өвчний талаарх хувь хүний мэдээлэл
4.	Иргэний эрүүл мэндийн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл болон түүний нөөц төвийн сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон программ хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо
5.	Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа цахим бүртгэл мэдээллийн сан болон түүний нөөц төвийн сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон программ хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо
6.	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
7.	Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч
8.	Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл
9.	Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг
10.	Албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж
11.	Байгууллага, харьяа байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт, шалгалт, үзлэг, тооллого хийсэн тухай тэмдэглэл
12.	Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүртгэлийн дэвтэр
13.	Нууц тээгчийг устгасан, олшруулсан баримт бичиг
14.	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл
15.	Эс, эд эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл
16.	Эмгэг судлалын задлан шинжилгээний протокол
	Зоонозын өвчин судлалын чиглэлээр:
17.	Тагнуулын байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр тусгайлан нууцалж, захиалсан сорьц, шинжилгээний хариу
18.	Байгалийн голомтот, зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омгийн төрөл, зүйл, тоог тусгасан баримт бичиг
19.	Байгалийн голомтот, зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омгийн паспорт, нарийвчилсан судалгааны бүртгэл, илрүүлсэн байршил, тархалтыг тэмдэглэсэн бүртгэл, газрын зураг
20.	Тэжээлт орчин, оношлуур, биобэлдмэл үйлдвэрлэлийн технологи
21.	Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөцийн бүртгэл
22.	Тэжээлт орчин, оношлуур, биобэлдмэл үйлдвэрлэлийн технологи түүний зааврууд

...оОо...